



**Тендер шалгаруулалт  
гэрээний нэр:**

**GMAIL GOOGLE OFFICE ПРОГРАММ  
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ  
БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалт  
гэрээний дугаар:  
ЭТТ/201901223**

**УЛААНБААТАР ХОТ  
2019 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**“Эрдэнэс-Таван Толгой” ХК** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Gmail, google, office”** нийлүүлэх тухай цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар илгээх ба үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 09 цаг 30 минутад нээнэ.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,  
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160,  
Утас: 75055555-508  
Холбоо барих ажилтан: Б.Цэцэгдолгор  
[tsetsegdolgor.b@erdenestt.mn](mailto:tsetsegdolgor.b@erdenestt.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.                              |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /компьютер, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байх/</li> <li>2. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар</li> <li>3. Татварын цахим тодорхойлолт өр дутуу үлдэгдэлгүй байх/тендер зарласан өдрөөс хойших байдлаар/.</li> <li>4. 2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт</li> <li>5. 2018 онд хийж гүйцэтгэсэн ижил төстэй, бараа материалыг нийлүүлсэн тухай гэрээ, акт, харилцагчийн тодорхойлолт. (ижил төстэй гэдэгт программ нийлүүлж байсан туршилга харгалзан үзнэ)</li> <li>6. Иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойших байдлаар/</li> <li>7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойших байдлаар/</li> <li>8. Монгол дахь албан ёсны эрх бүхий борлуулагч болохыг нотлох баримт ирүүлэх /Баталгаат орчуулгын хамт/</li> <li>9. Сургалтын агуулга, хөтөлбөр, сургагч багшийн мэдээлэл ирүүлэх</li> <li>10. Сургагч багшийн дипломын хуулбар ирүүлэх</li> <li>11. Нийлүүлэх барааны танилцуулгыг дэлгэрэнгүй ирүүлэх</li> <li>12. Бараа нийлүүлэх үнийн хуваарийг баталгаажуулан ирүүлэх.</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа:  Төрийн худалдан авах ажиллаганы цахим систем болох <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар цахимаар илгээнэ.  Огноо: <b>2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр</b>  Цаг: <b>09 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв. “Эрдэнэс-Таван Толгой” ХК, Улаанбаатар-15160</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>5 давхар, 503 тоот</b>  Огноо: <b>2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр</b>  Цаг: <b>09 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Байхгүй</b></p>

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**Хасвралт 1**

<b>№</b>	<b>Бараа болон холбогдох үйлчилгээний нэр</b>	<b>Техникийн тодорхойлолт болон стандарт</b>
<b>ОФФИС 365 ПРОГРАММ ЭСВЭЛ ТҮҮНТЭЙ ДҮЙЦЭХИЙГ НЭВТРҮҮЛЭХ</b>		
	<b>Office 365 Essential эсвэл түүнтэй дүйцэх /ашиглагдах хугацаа 6 сар/</b>	<b>180 хэрэглэгч</b>
1	Sharepoint, Flow ашиглан ПЭЙЖ үүсгэх, хөгжүүлэх, сургалт өгөх /Сургалтын цаг Бүх ажилтнуудад – 2 цаг Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд – 8 цаг/ /Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь уурхай, Төв оффист/	-Алба, хэлтэс бүрийн пэйж хуудсыг үүсгэх, хөгжүүлэлт хийх -Бичиг хэргийн процессыг автомжуулан цаасны хэрэглээг багасгах. -Төлөвлөгөө нормын процессыг бий болгох - Компанийн дотоод Пэйжийг үүсгэн бусад Sub пэйжүүдтэй холбох, -Судалгаа санал асуулгын формыг холбох -Шинэ ажилтан болон дотоод дүрэм журмын мэдээллийн санг бий болгох -Эрхийн түвшинг тогтоох (Засах, харах, устгах, үүсгэх гэх мэт)
2	Outlook, onedrive болон бусад оффисын хэрэглээний програмуудын тохиргоо болон сургалт /Сургалтын цаг Бүх ажилтнуудад – 1 цаг Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд – 2 цаг/ /Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь уурхай, Төв оффист/	Датагаа хэрхэн аюулгүй хадгалах, хуваалцах, хурал товлох, дотоод хурал, машин захиалах гэх мэт боломжууд Мөн Онлайн оффисын давуу тал, файлыг сэргээх, хиймэл оюун ухааныг ашиглах
3	Forms, Planner, Flow сургалт /Сургалтын цаг Бүх ажилтнуудад – 2 цаг Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд – 2 цаг/ /Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь уурхай, Төв оффист/	Судалгаа, санал асуулга, шалгалтын форм үүсгэх, ажлыг урт болон богино хугацаагаар төлөвлөх, тайлагнах, үр дүнг гаргах
4	Teams програмыг оновчтой зөв ашиглах, нэмэлт боломжуудыг ашиглах /Сургалтын цаг Бүх ажилтнуудад – 1 цаг Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд – 1 цаг/ /Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь уурхай, Төв оффист/	Алба хэлтэс багуудын дотоод групп үүсгэх шаардлагатай процессуудтай холбох
5	Admin center ашиглах /Сургалтын цаг Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд – 2 цаг/	Тайлан авах, эрх нээх, permission тогтоох, тохиргоо хийх, групп үүсгэх, хаах аюулгүй байдлын хамгаалалтыг бүтээх, lock хийх
6	Нэмэлт	Албан ёсны Майкрософт компанийн Монгол дахь партнер байх

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

№	Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэлтийн эхний хугацаа	Нийлүүлэлтийн эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Gmail, google office	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	180	хэрэглэгч	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төв оффисын байр	7 хоног	14 хоног	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах        | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1)                             | 1.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талыг төлөөлж захиалагчийн сонгосон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна.  |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5)                                  | 5.1. Гүйцэтгэгч тал нь нийлүүлж буй бараанд 1 жилээс доошгүй баталгаат засварын хугацаа гаргаж өгнө.  |
| 4. Төлбөр (ГЕН – 7)  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br>Гэрээнд заасан барааг <b>100</b> хувь нийлүүлсэн болохыг нотолсон барааг хүлээн авсан акт, нэхэмжлэх болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн ажлын 5 хоногийн дотор нийлүүлэгч талд бүрэн төлнө   |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) <sup>1</sup>                 | 9.1. Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн <b>[0.5%]</b> байна<br><br>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн <b>[10 хувь]</b> байна.  |

---

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*